

**МОНГОЛ ХЭЛ**

**2006**

## ХУВИЛБАР А

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

## Үншиж ойлгоод задлал хийх эх

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хаа холоос хүү минь ирэхээс эхэлнэ  
Хайр дурлал инээмсэглэлээс эхэлнэ  
Хаврын бороо, цэцгэнээс эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хадны жимс хувааж идэхээс эхэлнэ  
Халмаг насты нойронд хүү зүүдлэхээс эхэлнэ  
Харцага шувуу ноёлог уландаа бөөрөхөөс эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хаа хол хүний үр явахаас эхэлнэ  
Хасар басар нохой хөсөг дагахаас эхэлнэ  
Хангай хээрийн өвс халиурахаас эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хамгийн хөөрхөн чиний гараас цай уухаас эхэлнэ  
Хар модон ээрүүлтэй эмэг эх үүрэглэхээс эхэлнэ  
Харанхуй шөнийг гал гийгүүлэхээс эхэлнэ

/С.Нямсүрэн/

1. “... Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хамгийн хөөрхөн чиний гараас цай уухаас эхэлнэ  
Хар модон ээрүүлтэй эмэг эх үүрэглэхээс эхэлнэ  
Харанхуй шөнийг гал гийгүүлэхээс эхэлнэ” гэсэн хэсэгт жинхэнэ нэр хэд орсон байна вэ?  
A. 9              B. 8              C.7              D. 10              E. 2

2. 1-р сорилд байгаа өгүүлбэрт тохирох тодорхойлолтыг олоорой.  
A. Энгийн нийлмэл өгүүлбэр              B. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр  
C. Холимог нийлмэл өгүүлбэр              D. Угсарсан нийлмэл өгүүлбэр  
E. Харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

3. 1-р сорилд байгаа өгүүлбэрт жинхэнэ нэрийн найрах холбоо үг хэд байна вэ?  
A. 5              B. 1              C.4              D. 8              E. 2

4. 1-р сорилд байгаа өгүүлбэрийн “цай” гэдэг үг ямар гишүүн бэ?  
A. Өгүүлэгдэхүүн              B. Өгүүлэхүүн              C. Шууд тусагдахуун  
D. Тодотгол              E. Шууд бус тусагдахуун

5. 1-р сорилын хэсэгт ямар үгсийн аймгийн үг ороогүй вэ?  
A. Холбоу үг              B. Жинхэнэ нэр              C. Тэмдэг нэр  
D. Төлөөний үг              E. Үйл үг

6. 1-р сорилын хэсэгт нэрлэхийн тийн ялгалын тэг нөхцөлтэй үг хэд байна вэ?  
A. 5              B. 2              C. 4              D. 3              E. 1

7. “Эмэг эх” гэсэн холбоо үг ямар хобоо үг вэ?  
A. Чөлөөт              B. Үгийн санжсан              C. Хэлзүйжсэн  
D. Утгазүйжсэн              E. Бүхэлзүйжсэн

8. 1-р сорилын эхийн хэсэгт “тухайн үйл хөдлөлийг нэг, хоёр, гуравдугаар биеийн аль нэгээр гүйцэтгүүлэхээр хүсэх, гүйх, шийдэх, даалгах, захирах, зөвлөх, сануулах, зөвшөөрөх, шаардах, ерөх, мөрөөдөх зэрэг өгүүлэгч этгээдийн хандлагыг илтгэдэг төгсгөх нөхцөл”-тэй үг хэд байна вэ?  
A. 5              B. 1              C. 2              D. 3              E. Байхгүй

9. “Хувааж” гэдэг хэлзүйн үгтэй ойролцоо хэлбэрийг ол.  
A. Хуваан              B. Хуваангаа              C. Хуваамагц              D. Хуваасаар              E. Хуваажээ

10. “Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хaa холоос хүү минь ирэхээс эхэлнэ.....” гэдгийн “хaa холоос хүү ирэхээс эхэлнэ” гэдэг мөрийн эсрэг утгатай илэрхийллийг ол.

- A. Хүүгээ хүссэн эхийн сэтгэл баясах  
 B. Ирсэн гийчин буцдаг  
 C. Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөртлөн ирнэ  
 D. Цэргийн хүүхдүүд ирлээ  
 E. Намар сургууль цуглах сайхан
11. “Ээрүүлтэйгээ” гэдэг үг хэдэн авиа хэдэн үсэг вэ?  
     A. 9 авиа 12 үсэг                             B. 4 авиа 4 үсэг  
     D. 8 авиа 12 үсэг                             E. 12 авиа 12 үсэг                             C. 7 авиа 12 үсэг
12. Эхийн сэдвийг ол.  
     A. Хайр сэтгэл                                     B. Амьдрал сайхан  
     D. Байгалийн сайхан                             E. Малчны мөрөөдөл                                     C. Жил жилийн баяр
13. Эхийн санааг хэлнэ үү.  
     A. Улирал бүхэн өөр өөрийн өнгө зүс, баяр баяслын эх  
     B. Нуудэлчин ардын ахуй амьдрал сайхан  
     C. Хайртай хүүтэйгээ уулзах сайхан  
     D. Чинийхээ гараас цай уух даанч сайхан  
     E. Ийм сайхан байгалийт хамгаалах хэрэгтэй
14. “Халмаг насны нойронд хүү зүүдлэхээс эхэлнэ...” гэсэн өгүүлбэрийн найруулах ур маягийг ол.  
     A. Зүйрлэл   B. Адилтгал   C. Егөөдөл  
     D. Ёгтол   E. Төлөөлөл
15. “Халмаг насны нойрондоо хүү зүүдэлнэ” гэдэг мөрийн “халмаг насны” гэдэг үгэнд ямар далд утга байна вэ?  
     A. Хalamцуу гөлөмцүү үе                             B. Ааг омог амтагдсан залуу нас  
     C. Харьж явваа хайлган цаг                             D. Эр бие тэгширсэн идэр сайхан цаг  
     E. Хайрандаа шатсан залуу халуун нас
16. “... Хасар басар нохой хөсөг дагахаас эхэлнэ  
     Хангай хээрийн өвс халиурахаас эхэлнэ...” гэсэн хэсгээр юуг дүрслэв?  
     A. Наадмын дараах намар                             B. Хол газраас хүү ирэх хавар  
     C. Хайр жимс болж амтагдсан зун цаг                     D. Өвлийн амгалан шөнө  
     E. Малчин айлын сайн туслах хоточ нохойн дүрслэл
17. Дараах эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?  
     “Нийслэлийн эргэн тойрон Толгойтын зүүн, баруун салаа, Баянзүрх, Улиастайд мод бэлтгэгчид ихэссэнтэй холбогдуулан УМХГ, ЦЕГ, БОЯ хамтран тавдугаар сард хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлжээ. Одоогийн байдлаар нийт 15 машин мод хураагаад байгаагас 1500 гаруй палк, 20 куб метр мөдиг улсын орлогод хураагаад байна”  
     A. Ярианы найруулга                                     B. Сонины найруулга                                     C. Албан бичгийн найруулга  
     D. Шинжлэх ухааны найруулга                             E. Уран зохиолын найруулга
18. “Хараацайн жигүүр шиг тахиралсан  
     Нарийн сайхан хөмсгөөрөө  
     Харзны ус шиг мэлтэлзсэн  
     Намуун зөөлөн аашаараа” гэсэн дууны үгэнд найруулгын ямар алдаа байна вэ?  
     A. Үг буруу сонгосон                                     B. Учирзүйн алдаа  
     C. Зүйрлэл буруу сонгосон                             D. Найруулгын алдаагүй сайн дууны үг болсон  
     E. Хэлзүйн алдаа
19. Дараах жагсаалтыг уншаад буруу зүйлчилсэн хэсгийг ол.  
     A. Төрийн сүлд соёмбо, байгууллагын нэр, байгууллагын хаяг, илгээж байгаа бичгийн нэр, огноо, арын үсэг, тамга, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэл  
     B. Заавар, тайлан, мэдэгдэл, төсөл, хөтөлбөр, санал танилцуулга, албан даалгавар, шийдвэр  
     C. Найруулал, шог найруулал, сурвалжилга, тэмдэглэл, зарлиг, гашуудлын мэдээ, хөрөг нийтлэл  
     D. Нэвтэрхий толь, гарын авлага, өгүүлэл, дасгалын хураамж, зөвлөмж, ганц сэдэвт зохиол, хэрэглэх заавар  
     E. Роман, тууж, өгүүллэг, шүлэг, найраглал
20. Доор өгөгдсөн эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.  
     “40-60см өндөр, дээш нарийссан бүдүүн хөндий цоор иштэй, түүний оройд шаравтар багцтай. Ишнээсээ арай богиновтор хөндий цоор навчистай, гадуураа олон давхар хүрэвтэр хальс бүхий уртавтар бүдүүн сонгинотой. Уулын сонгино өндөр уулын хайрга, чулуу асга нурагтай хажуу энгэр хадны ёроол, ан цав дагаж ургана”  
     A. Тоочимж   B. Хүүрнэмж   C. Тайлбарламж  
     D. Эргэцүүлэмж   E. Дүрслэмж

## Боловсролын Үнэлгээний Төв

21. Холбоо үгсийг утга үнэлэмжмийн талаас ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.  
Атигархан буурал ижий, торойгоод л хоцордог ижий минь, цагийн салхинд уймарсан ижий, элэгдсэн дээлтэй ижий минь,...

А. Буйлс цэцэглүүлэм сайхан ээж  
Б. Ертөнцийн чимэг ээж  
С. Наран гэрлийн илчтэй саран гоо ижий минь  
Д. Суутай мэргэдээс илүүтэй сургаал хайрласан ижий  
Е. Жилээс жилд жижгэрсэн ээж

22. “Бүтээгдэхүүнээ борлууллаа” гэсэн өгүүлбэрт байгаа “бүтээгдэхүүнээ” гэсэн үгийг зөв задалсан тохиолдлыг ол.

А. Бүтээ + гд + хүүн + ээ  
Б. Бүт + ээ + г + дэх+ үүн+ ээ  
С. Бүт + ээ+ гд + хүүн + о-/ийг/ ээ  
Д. Бүтээ + гд+ х + үүн + ээ  
Е. Бү + тээгд + хүү + нээ

23. Дараах үгсийн утгын дарааллыг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.  
Гучин хэдэн, хорь шахам, ная гаруй, зуугаад, ....

А. Арван тавул  
Б. Мянга орчим  
С. Тавантаа  
Д. Гурав дахь  
Е. Гучдугаар

24. Дараах жагсаалтаас хэлзүйн шинжээрээ хоорондоо үл тохирч байгаа хэсгийг ол.

А. Ба, бегоод, буюу, агаад, болоод  
Б. Зарим, бүгд, би, аль, ийм  
С. Дээр, наана, цаана, дэргэд, хааяа  
Д. Нэн, бүү, маш, тун, тутам  
Е. Шар, цэхэр, бор, зээрд, дугуй

25. Дараах хэлцүүдийн утга, дарааллын зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг нь ол.  
Нүдэн балай чихэн дүлий, ум хумгүй, мэдэхгүй царайлсан, ухаан жолоогүй, дүлий дүмбэ оргисон, .....

А. Илжиг шиг зөрүүд  
Б. Буруу ишилсэн сүх шиг  
С. Эргүү төлөг шиг  
Д. Хуйхуйд хөөгдсөн юм шиг  
Е. Доль цохисон

26. “Санаа нь дэлхий, сачий нь.....” гэсэн хэллэгийн цэгийн оронд тохирох үгийг ол.

А. Чоно  
Б. Мэлхий  
С. Хонь  
Д. Хорхой  
Е. Шалбааг

27. Дараах үйл үндсүүдэд –гд нөхцөл залгахад аль нь бусдаасаа өвөрмөц дүрмээр бичигдэх вэ? /кирилл/

А. Бoo  
Б. Сана.  
С. Хар  
Д. Нээ  
Е. Оно

28. Урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгавал аль үг нь бусдаасаа өвөрмөц дүрмээр бичигдэх вэ? /кирилл/

А. Нуу-  
Б. Сана-  
С. Уна-  
Д. Эргэ-  
Е. Мана-

29. Зөв бичгийн дүрмээр бүх үг нь алдаагүй бичсэн хэсгийг ол.

А. Нөхдөөө, бусаддаа, үзснийг, уяа  
Б. Тосоль ё, уулзсанаас, оёё, тугаллаа  
С. Галлалаа, нүүдэллээ, аяллаа, тусаллаа  
Д. Хувцасла, цэвэрлэ, хавтасла, гуравлалаа  
Е. Боддогийг, ярьдагийг, авдагийг, үздэгийг

30. Монгол бичгээр бичихэд дервөн үеэс бүтэх үгийг ол.

А. Хэмнэл  
Б. Таримал  
С. Санамж  
Д. Элст  
Е. Элсэлт

31. Монгол бичгээр аль үйл үг нь хатуу дэвсгэрээр төгсех вэ?

А. Чад  
Б. Гомд  
С. Дэлд  
Д. Шид  
Е. Уд

32. Дараах хэсгийг унш. Хэний ямар зохиолоос авсан байна вэ?  
“Баянмонголын хонь ямаан сүргээ гэсэн үг аятайгаа радио хоолойгоор хөврөх нь тун бүдэг сонстлоо. Дугаржавын нүднээс өөрийн эрхгүй дусал нулимс бөнжигнөн гарлаа. Зохиосон дууныхаа аяаг гяндны зузаан хананы цаанаас сонсоход төрсөн үр, амраг ханытайгаа уулзсанаас ялгаагүй, сэтгэл додглон, бүх бие додглов”

А. Б. Ринчен “Ану хатан”  
Б. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир”  
С. Түдэв “Хувьсгал танаа очье”  
Д. С.Удвал “Их хувь заяа”  
Е. Б. Ринчен “Гүнж”

33. “Монголын нууц товчоо” зохиолд:  
“Хар хэрээ нугасыг барих болов  
Харц боол хан эзэндээ халдах болов  
Хаан анд минь хайрлаж өршөө  
Бор элээ борлог нугасыг барих болов...” гэж хэнээс хандаж хэнд хэлдэг вэ?

А. Тэмүжинээс Жамухыг барьсан 5 хүнд хэлсэн үг  
Б. Таргудайг тавиад Тэмүжинд дагаар орсон Алаг Наяагийн хэлсэн үг  
С. Жамухаас Тэмүжин андад хэлсэн үг  
Д. Ван ханаас Тэмүжинд хэлсэн үг  
Е. Алтан хаанаас Тэмүжинд хэлсэн үг

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

Хүхдүүд ээ, 2-р хэсгийн даалгавар сонгох тест биш бөгөөд та нар өөрсдөө бодож хариуг бөглөх юм шүү. Дараах хэлцүүдийг утга тохиуулан 2.1 хэсгт бөглөнө үү. Зөв хариулт бурд нэг онoo өгнө. (нийт онoo 8)

- |                              |                               |
|------------------------------|-------------------------------|
| 1. Гүзээ шороодох            | a. Усан нүдэт цусан зүрхт     |
| 2. Үнэг гүйцэх               | б. Магнай тэндийх             |
| 3. Дүштийн оронд гарах       | с. Эвэртэй туулай үзэх        |
| 4. Ташуур алдам              | d. Жанч халах                 |
| 5. Нүцгэн хөлт сээр нуруутан | е. Гунан үхрийн эвэр хөлдмөөр |
| 6. Нүд нь орой дээрээ гарах  | f. Дотор газраас өр нэхэх     |
| 7. Ширэн нүүрлэх             | g. Цаасан малгай өмсгөх       |
| 8. Давирхай халаах           | h. Ичих нүүрэндээ элгээ наах  |

# ХУВИЛБАР В НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

## Үншиж ойлгоод задлаал хийх эх

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хаа холоос хүү минь ирэхээс эхэлнэ  
Хайр дурлал инээмсэглэлээс эхэлнэ  
Хаврын бороо, цэцэгнээс эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хадны жимс хувааж идэхээс эхэлнэ  
Халмаг насты нойронд хүү зүүдлэхээс эхэлнэ  
Харцага шувуу ноёлог ууланд бөөрөхөөс эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хаа хол хүний үр явахаас эхэлнэ  
Хасар басар нохой хөсөг дагахаас эхэлнэ  
Хангай хээрийн өвс халиурахаас эхэлнэ

Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хамгийн хөөрхөн чиний гараас цай уухаас эхэлнэ  
Хар модон ээрүүлтэйгээ эмгэж эхэлнэ  
Харанхуй шөнийг гал гийгүүлэхээс эхэлнэ /С.Нямсүрэн/

1. Эхийн сэдвийг ол.
    - А. Хайр сэтгэл
    - Б. Амьдрал сайхан
    - С. Жил жилийн баяр
    - Д. Байгалийн сайхан
    - Е. Малчны мөрөөдөл
  2. Эхийн санааг хэлнэ үү.
    - А. Улирал бүр өөр өөрийн өнгө зүстэй
    - Б. Нүүдэлчин ардын ахуй амьдрал сайхан
    - С. Хайртай хүүтэйгээ уулзах сайхан
    - Д. Чинийхээ гараас цай уух даанч сайхан
    - Е. Ийм сайхан байгалийг хамгаалах хэрэгтэй
  3. “Халмаг насны нойронд хүү зүүдлэхээс эхэлнэ...” гэсэн өгүүлбэрийн найруулах ур маягийг ол.
    - А. Зүйрлэл
    - Б. Адилтгал
    - С. Егөөдөл
    - Д. Ёгтлол
    - Е. Төлөөлөл
  4. “Халмаг насны нойрондоо хүү зүүдэлнэ” мөрийн “халмаг насны” гэдэг үгэнд ямар далд утга байна.
    - А. Халамцуу гөлөмцүү үе
    - Б. Ааромог амтагдсан залуу нас
    - С. Харьж яваа хайлган цаг
    - Д. Эр бие тэгширсэн идэр сайхан цаг
    - Е. Хайрандаа шатсан залуу халуун нас
  5. “...Хасар басар нохой хөсөг дагахаас эхэлнэ  
Хангай хээрийн өвс халиурахаас эхэлнэ...” гэсэн хэсгээр юуг дүрслэв?
    - А. Наадмын дараах намар
    - Б. Хол газраас хүү ирэх хавар
    - С. Хайр жимс болж амтагдсан зун цаг
    - Д. Өвлүйн амгалан шөнө
    - Е. Малчин айлын сайн туслах хоточ нохойн дүрслэл
  6. “...Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
Хамгийн хөөрхөн чиний гараас цай уухаас эхэлнэ  
Хар модон ээрүүлтэйгээ эмэг эх үүрэглэхээс эхэлнэ  
Харанхуй шөнийг гал гийгүүлэхээс эхэлнэ” гэсэн хэсэгт жинхэнэ нэр хэд орсон байна вэ?
    - А. 5
    - Б. 8
    - С. 7
    - Д. 10
    - Е. 2
  7. 6-р сорилд байгаа өгүүлбэрт тохиорох тодорхойлолтыг олоорой.
    - А. Энгийн нийлмэл өгүүлбэр
    - Б. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
    - С. Холимог нийлмэл өгүүлбэр
    - Д. Угсарсан нийлмэл өгүүлбэр
    - Е. Харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

8. 6-р сорилд байгаа өгүүлбэрт жинхэнэ нэрийн найрах холбоо үг хэд байна вэ?  
 A. 5      B. 1      C. 4      D. 8      E. 9
9. 6-р сорилд байгаа өгүүлбэрийн “цай” гэдэг үг ямар гишүүн бэ?  
 A. Өгүүлэгдэхүүн      B. Өгүүлэхүүн      C. Шууд тусагдахуун  
 D. Тодотгол      E. Шууд бус тусагдахуун
10. 6-р сорилын хэсэгт ямар үгсийн аймгийн үг ороогүй вэ?  
 A. Холбоо үг      B. Жинхэнэ нэр      C. Тэмдэг нэр  
 D. Төлөөний үг      E. Үйл үг
11. 6-р сорилын хэсэгт нэрлэхийн тийн ялгалтай үг хэд байна вэ?  
 A. 1      B. 2      C. 3      D. 4      E. 5
12. “эмэг эх” гэсэн холбоо үг ямар холбоо үг вэ?  
 A. Чөлөөт      B. Үгийн санжсан      C. Хэлзүйжсэн  
 D. Утга зүйжсэн      E. Бүхэлзүйжсэн
13. 6-р сорилын эхийн хэсэгт “тухайн үйл хөдлөлийг нэг, хоёр, гуравдугаар биесийн аль нэгээр гүйцэтгүүлэхээр хүсэх, гүйх, шийдэх, даалгах, захирах, зөвлөх, сануулах, зөвшөөрөх, шаардах, ерөөх, мөрөөдөх зэрэг өгүүлэгч этгээдийн хандлагыг илтгэдэг төгсөх нөхцөл”-тэй үг хэд байна вэ?  
 A. 5      B. 1      C. 2      D. 3      E. Байхгүй
14. “Хадны жимс хувааж идэхээс эхэлнэ” гэдгийн “хувааж” хэмээх хэлзүйн үтгэй ойролцоо хэлбэрийг ол.  
 A. Хуваан      B. Хуваангаа      C. Хуваамагц  
 D. Хуваасаар      E. Хуваажээ
15. “Хамаг юм сайн сайхнаас эхэлнэ  
 Хaa холоос хүү минь ирэхээс эхэлнэ ...” гэдгийн “хаа холоос хүү ирэхээс эхэлнэ” гэдэг мөрийн эсрэг утгатай илэрхийллийг ол.  
 A. Хүүгээ хүссэн эхийн сэтгэл баясах  
 B. Ирсэн гийчин буцдаг  
 C. Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөртлөн ирнэ<sup>1</sup>  
 D. Цэргийн хүүхдүүд ирлээ  
 E. Намар сургууль цуглах сайхан
16. “Ээрүүлтэйгээ” гэдэг үг хэдэн авиа хэдэн үсэг вэ?  
 A. 9 авиа 12 үсэг      B. 4 авиа 4 үсэг      C. 7 авиа 12 үсэг  
 D. 8 авиа 12 үсэг      E. 12 авиа 12 үсэг
17. “Жинхэнэ нэр, ерийн, үүсмэл, ганц тоо, гарахын тийн ялгалд байгаа, хамаатуулах нөхцөл аваагүй” гэх шинжид тохирох үгийг ол.  
 A. Инээмсэглэлээс      B. Цэцэгнээс      C. Зүүдлэхээс  
 D. Гараас      E. Сайхнаас
18. Дараах үйл үндсэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад аль нь бусдаасаа онцлог бичигдэх вэ? /кириллээр/  
 A. Судал      B. Буцал      C. Зажил  
 D. Арил      E. Гашил
19. Нэрээс үйл үг бүтээх -л дагавар залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ? /кириллээр/  
 A. Ax      B. Хайч      C. Tos  
 D. Sav      E. Nogt
20. Зөв бичгийн дүрмээр бүх үгийг алдаагүй бичсэн үгийг ол.  
 A. Тусла, бусаддаа, үзснийг, уяяя      B. Тосольё, нөхөддөө, уулзсанаас, оёё  
 C. Аял, эвлэ, насал, нүүдэллээ      D. Хувцасла, цэвэрлэ, хавтасла, цэгцэл  
 E. Боддогийг ярьдагийг, авдгийг, үздэгийг
21. Монгол бичгээр бичихэд хоёр үеэс бүтэх үгийг ол.  
 A. Узэгдэл      B. Урвал      C. Нэгдэл  
 D. Нягтрал      E. Чулуу
22. Монгол бичгээр бичихэд аль үг нь хатуу дэвсгэрээр төгсөх вэ?  
 A. Амс      B. Хүс      C. Жагс  
 D. Урс      E. Зас
23. Дараах хэсгийг унш. Хэний ямар зохиолоос авсан байна вэ?  
 ...Жаргал зовлонг энэ улстай холbon хамтатгасан зовлогон биесий минь зовлонт боловч зоригт Монголын нутагт оршуул! Төр чинь мөнх биш. Түмэн мөнх!  
 A. Б.Ринчин “Ану хатан”      B. Л.Түдэв “Хувьсгал танаа өчье”  
 C. С.Удвал “Их хувь заяа”      D. Б.Ринчен “Гүнж”  
 E. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир”

## Боловсролын Үнэлгээний Төв

24. “Монголын нууц товчоо” зохиолд “...Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулахад чи үзэх нүд, сонсож чих болж яв. Бидний эх ба дүү нар хөвгүүдэд эсгий туургатны дотроос эзлэх хувийг олгож, хавтсан үүдтэний дотроос харьалах ардыг хувааж өг... . Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж яллах ёстойг яллаж бай ... заргыг шийтгэж түүнийгээ хөх дэвтэрт бичиж тэмдэглэгтүн” хэмээсэн яриа хэн хэний хооронд гардаг вэ?

А. Чингис хаан Елюу Чуцай  
Б. Ван хаан Тэмүүжин  
С. Алтан Хучар нар Тэмүүжиннд  
Д. Чингис хаан Шигихутуг  
Е. Таян хаан Тэмүүжин

25. Шүлгийн мөрийг уншаад, өгүүлсэн баатрын нэрийг өгөгдсөн хувилбаруудаас зөв сонго.  
“... Аманд орохдоо алтан шумуул мэт  
Амнаас гарахдаа арслан заан боссон мэт  
Хэлэнд амсаход хэдгэнэ шумуул мэт  
Хэлнээс гарахдаа хэдэр заан боссон мэт...”

А. Чу мэргэн  
Б. Баорчи  
С. Мухулай  
Д. Сорхон шар  
Е. Ончин хүү

26. Дараах хувилбаруудыг ажиглаад, төрөл зүйлээр бүрэн ижилссэн хэсгийг олно уу.

А. Улгэр, өгүүллэг, туульс, тууж  
Б. Дууль, улгэр, домог, өгүүллэг  
С. Өгүүллэг, тууж, роман, бэсрэг тууж  
Д. Оньсого, цэцэн үг, роман, магтаал  
Е. Оньсого, магтаал, өгүүллэг, хууч яриа

27. “АНУ-ын нийслэл Нью-Йорк хотод Греммийн шагнал гардуулах ёслол болж өнгөрлөө” гэсэн хэсэгт найруулгын ямар алдаа байна вэ?

А. Үгийн өнгө аяс гажсан  
Б. Үг буруу сонгосон алдаа  
С. Баримтын алдаа  
Д. Найруулгын алдаагүй  
Е. Хэлзүйн алдаа

28. Дараах жагсаалтыг уншаад, буруу зүйлчилсэн хэсгийг ол. (Найруулгын төрөл, бичлэгийн онцлогийг харгалзана)

А. Төрийн сүлд соёмбо, байгууллагын нэр, байгууллагын хаяг, илгээж байгаа бичгийн нэр, огноо, гарын үсэг, тамга, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэл  
Б. Заавар, тайлан, мэдэгдэл, төсөл, санал танилцуулга, албан даалгавар, шийдвэр, эссе  
С. Найруулал, шог найруулал, сурвалжилга, тэмдэглэл, гашуудлын мэдээ, хөрөг нийтлэл, ярилцлага  
Д. Нэвтэрхий толь, гарын авлага, өгүүлэл, дасгалын хураамж, зөвлөмж, сурх бичиг, нэг сэдэвт зохиол  
Е. Роман, тууж, өгүүллэг, найраглал, домог, шүлэг, бэсрэг тууж

29. Дараах загвар ямар найруулгынх вэ?

  - Намтын хэсэг (Хэний хэн. Хэдэн онд хаана төрсөн. Ам бүл. Төгссөн сургууль курс. Эзэмшил мэргэжил Гишүүнчлэл)
  - Ажлын байдал (Хэдээс хэдэн онд хаана ямар ажил хийж байсан. Одоогийн ажил юу болох)
  - Ажлын буюу сурлагын амжилт юу болох. (Гаргасан санаачилга, бүтээл туурвил)
  - Гавьяа шагнал (...)
  - Үнэлэлт
  - Тодорхойлолт
 

А. Ажил байдлын тодорхойлолтын найруулга	Б. Ярианы найруулага
С. Магадлах тодорхойлолтын найруулга	Д. Шинжлэх ухааны найруулага
Е. Сонин нийтлэлийн найруулага	

30. Өгөгдсөн эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.  
“Хүмүүс тоосыг хараан “муу тоос, муухай тоос” л гэнэ. Чухамдаа бол тоос гэгч газрын бор шим, шар чөмөг нь юм. Газрын өнгө хийгээд жавхaa үр цэцгийн эсээ, үр цэцгийн нь өнгө хийгээд үзэсгэлэн эрдэс шимээсээ, эрдэс шимиийн нь өл хийгээд өгөөж огторгуйн алганаа хурсан тоос товрогноос нь бүрдэнэ л!”

А. Тоочимж  
Б. Тайлбарламж  
Д. Хүүрнэмж  
Е. Оньсоголомж

31. Холбоо үгсийг утга үнэлэмжийн талаас ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.  
Сэгсэрг буурал ээж, торойгоод үлдсэн ижий, гандуу дээлтэй ижий, атигархан буурал ижий, цагийн салхинд уймарсан ижий минь

А. Бүүвэйн дуу аялсан ижий  
Б. Суутай мэргэдээс илүүтэй сургаал хайрласан ижий минь  
С. Бүйлс цэцэглүүлэх сайхан ижий  
Д. Эгмээс минь татаж эрийн зэрэгт оруулсан ээж минь  
Е. Жилээс жилд жижгэрсэн ... ээжий минь

32. “Саравчлан суугаа ижий” гэсэн өгүүлбэрт байгаа “саравчлан” гэсэн үгийг зөв задалсан тохиолдлыг ол.
- A. Cap + вч + л + н      B. Cap + вчил + н      C. Саравч + л + н  
D. Cap + вч + лан      E. Саравч + лан
33. Дараах жагсаалтаас хэлзүйн шинжээрээ үл тохирч байгаа хэсгийг ол.
- A. Дээр, наана, цаана, дэргэд, хааяа      B. Зарим, бүгд, би, аль, ийм  
C. Болоод, бүхэн, агаад, буюу, болон      D. Нэн, бүү, маш, тун, биз  
E. Шар, цэхэр, бор, зээрд, дугуй
34. Дараах үгсийн утга, дарааллын зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.  
Өөртөө лай хураах, түнжин хагарах, даахгүй нохой булуу цуглуулах, муур нохой хоёр шиг, түүгээр явсан гайг үүгээр дуудах
- A. Шар нь гозойх      B. Ямаан омог нь хөдлөх      C. Өглөө хазаар, орой ташуур  
D. Гэдсэндээ хөлөө жийлцэх      E. Улаан хөлтийг урдуураа гишгүүлэхгүй
35. “ухнанд явсан хүү ..... ирэх” гэсэн зүйр хэллэгийн цэгийн оронд тохирох үгийг ол.
- A. Үд өнгөрсөн хойно      B. Ямаа ишиглэсэн хойно      C. Улсын наадмаар  
D. Ухнаа алдаад ирэх      E. Ямаа самнасан хойно
36. Дараах нийлмэл үгийн бүтцийг ажиглаад, бусдаасаа ялгаатай үгийг ол.
- A. Ухэр тэрэг      B. Мөсөн чихэр      C. Алтан гагнуур  
D. Шар шувуу      E. Ямаан арц
37. Дараах жагсаалтад үл тохирох үгийг ол.
- A. Хар элгийн      B. Элэг хөших      C. Элэг барих  
D. Элэг нэгтэй      E. Элэг идэх
38. Аль хэсэгт нь үеэр зөв тасалсан байна вэ?
- A. Бэх - жүү - лэ - хийн      B. Бэх - жүүл - эх - ийн      C. Бэх - ж - үүл - эх - ийн  
D. Бэх - жүү - лэх - ийн      E. Бэх - ж - үүл - х - ийн
39. “хадны” гэдэг үгийн “н” авиад үл тохирох шинжийг ол.
- A. Хамжих      B. Чанга дуугүй      C. Хатуу  
D. Хамрын      E. Хэлний урдуур
40. Дараах дөрвөн хэсгийг зөв байрлуулбал яруу найрагч Ш.Уянгын нэгэн шүлэг болно.
1. Эдүгээ хүртэл эх хэл Таныхаа өлгийд би нялхаараа  
Эртний мэргэн үгсийн сангаас тань хөхөж бойжсон хэвээрээ
  2. Гэрийн бүслүүр чивчиртэл намайг чарлаж мэндлэхэд  
Гээзгэнээсээ таслан хүйг минь боосон саахалтын буурал эмээ
  3. Гайхамшигтай соёлоо цаг хугацааны гүн рүү би тээсээр...  
Газар широо минь ертөнцийн мэдрэмж надад хайлласаар...
  4. “Төрийн минь сүлд өршөө! Хүү төрлөө!” гэж уулга алдсан  
Төгөлдөр тансаг эх хэлтэйгээ би тэгэхэд учирсан
- A. 4, 2, 3, 1      B. 2, 4, 1, 3      C. 2, 3, 4, 1  
D. 2, 3, 1, 4

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

**Хүүхдүүд ээ, 2-р хэсгийн даалгавар сонгох тест биш болох та нар өөрсдөө бодож хариуг бөглөх юм шүү.  
Дараах хэлцүүдийг утга тохируулан 2.1 хэсэгт бөглөнө үү. Зөв хариулт бүрд нэг оноо өгнө. (Нийт оноо 8)**

- |   |   |
|---|---|
| 1. Гүзээнд наалдсан дэлүү шиг           | a. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий бэлдэх      |
| 2. Гүзээ шороодох                       | b. Хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав |
| 3. Могой гурав тасравч гүрвэлийн дайтай | c. Цаасан малгай өмсгөх                     |
| 4. Ташуур алдам                         | d. Аавын цээж                               |
| 5. Бяруу болоогүй байж бух болох        | e. Ухсэн буурын толгойноос амьд ат айна     |
| 6. За гэвэл ёогүй                       | f. Чөтгөр тогтмооргүй                       |
| 7. Давирхай халаах                      | g. Хадан гэртээ очих                        |
| 8. Алаагүй үнэгний арьс                 | h. Нойтон хамуу                             |

**ХУВИЛБАР С  
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

**Үншиж ойлгоод задлал хийх эх**

Арван зуун биднийг тусгаарлаж  
Алтайн нуруу шиг хөндөлдөнө  
Оддын туяанд чамайг би төсөөлж  
Он жилийн энэ эргээс шүлгээ илгээнэ  
Чиний ирэх эрэгт бодол минь хүрэхэд  
Чийгт үдшийн агаарт би уусна ...  
Оршин буй хоосон зайд чинь намайг шилжихэд  
Оронд минь ирэх чи, миний тухай төсөөлөл мэтгэнэ  
Гудамж байшинг нь би мэдэхгүй  
Гучдугаар зуун ... гэж хаяглана  
Ямар ч унаа эндээс зүглэхгүй алсад  
Яруу найргаар дамжин би очно!  
Одод гийсэн үдэш цонхны цаана суухад чинь  
Он жилийг туулсан миний алхаа сонсдоно  
Цонхны чинь хөшиг шажигнан, би орж очно  
Цочихдоо чи шүлгийн минь түүврийг гараасаа алдана  
Үл үзэгдэх миний намуухан дууг сонсохдоо  
Үлэмж гоо охин чи айх хэрэггүйг ухаарна  
Буурал хорвоод мянган жилийн өмнө амьдраад  
Буцаад явчихсан найрагч эргэж ирснийг ойлгоно

1. Эхийн сэдвийг ол.  

A. Эргэн дурсахуй	B. Яруу найраг	C. Үдэш
D. Хайр сэтгэл	E. Гучдугаар зууны охин чамд	
2. Эхийн санааг ол.  

A. Одод гийсэн шөнө үзэсгэлэнт охин чам дээр очно	B. 30-р зууны гоо охин чамд захидал илгээмүй	C. Эд нь хэврэг эзэн нь мөнх
D. Хүний гараар бүтэшгүй хөшөө дурсгалаа босгов, би	E. Гэрэлт ирээдүй	
3. Эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ?  

A. “Яруу найргаар дамжин чам дээр очно” гэдэг бүхэлдээ нэг цогцолбор	B. Шүлгээ илгээж яруу найргаар очно” гэсэн 1 цогцолбор, чи намайг хүлээж авна” гэсэн 1 цогцолбор нийт 2 цогцолбор	C. “...чамайг төсөөлж шүлгээ илгээнэ”, “...чи миний тухай төсөөлөл мэтгэнэ”, “... найргаар дамжин би очно”, “... түүврийг минь гараасаа алдаадаа найрагч ирснийг ойлгоно” гэсэн нийт 4 цогцолбор
D. “... хөндөлдөнө”, “... илгээнэ”, “... уусна”, “... мэтгэнэ”, “... хаяглана”, “... дамжин очно”, “... алхаа сонсдоно”, “... гараасаа алдана”, “... ухаарна”, “... ойлгоно” гэсэн нийт 10 цогцолбор	E. “... бие биеэ төсөөлцгөөнө”, “... алхаа минь сонсогдож би очно”, “... яруу найрагч эргэж ирснийг ойлгоно” гэсэн 3 цогцолбор	
4. “Арван зуун биднийг тусгаарлаж  
Алтайн нуруу шиг хөндөлдөнө” гэсэн хэсэгт найруулгын ямар ур маяг орсон байна вэ?  

A. Амьдчилал	B. Зүйрлэл	C. Адилтгал
D. Тойруулал	E. Төлөөлөл	
5. “Гудамж байшинг нь би мэдэхгүй  
Гучдугаар зуун ... гэж хаяглана” гэсэн мөртэй утга үнэлэмжээрээ хамгийн ойр хувилбарыг сонгоно уу.  

A. Сэргүүн зүүд	B. Гэгээн алс	C. Ирэх зуун
D. Манан будантай ирээдүй	E. Арван зууны дараа	
6. “Үл үзэгдэх миний намуухан дууг сонсохдоо  
Үлэмж гоо охин чи айх хэрэггүйг ухаарна  
Буурал хорвоод мянган жилийн өмнө амьдраад  
Буцаад явчихсан найрагч эргэж ирснийг ойлгоно” гэсэн эхэд үйл үг хэд орсон байна вэ?  

A. 10	B. 9	C. 11	D. 8	E. 7
-------	------	-------	------	------



25. Шүлгийн мөрийг уншаад өгөгдсөн хувилбаруудаас зохиолчийн нь нэрийг зөв сонго.

“Газрын нүдэн булгийн чинь  
Хад цоолсон цамнаа  
Намайг эрэмгий болгосон”

А. Б.Лхагвасүрэн  
Д. М.Цэдэндорж

В. Б.Явуухулан  
Е. О.Дашбалбар

С. Р.Чойном

26. Дараах хувилбаруудыг ажиглаад төрөл зүйлээр бүрэн ижилссэн хэсгийг олно уу.

А. Оньсого, цэцэн үг, тууж, магтаал  
С. Өгүүллэг, туульс, найраглал, шүлэг  
Е. Оньсого, магтаал, ерөөл, зүйр цэцэн үг

В. Үлгэр, өгүүллэг, туульс, тууж  
Д. Дууль, үлгэр, домог, өгүүллэг

27. “Бүх оддын тогтолт болно” гэсэн хэсэгт найруулгын ямар алдаа байна вэ?

А. Үгийн өнгө аяс гажсан  
Д. Хэлзүйн алдаа  
Б. Учирзуйн алдаа  
Е. Найруулгын алдаагүй

28. Дараах жагсаалтыг уншаад буруу зүйлчилсэн хэсгийг ол. (найруулгын төрөл, бичлэгийн онцлогийг харгалзана)

А. Төрийн сүлд соёмбо, байгууллагын нэр, байгууллагын хаяг, илгээж байгаа бичгийн нэр, огноо,  
гарын үсэг, тамга, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэл  
Б. Заавар, тайлан, төсөл, санал танилцуулга, албан даалгавар, шийдвэр  
С. Найруулал, шог найруулал, сурвалжилга, тэмдэглэл, гашуудлын мэдээ, хөрөг нийтлэл, ярилцлага,  
мэдэгдэл  
Д. Нэвтэрхий толь, гарын авлага, өгүүллэл, дасгалын хураамж, зөвлөмж,  
Е. Роман, тууж, өгүүллэг, найраглал, домог, шүлэг, бэсрэг тууж, ерөөл

29. Дараах эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?

Цэмбэний наймаачин Левенгук болон түүний нөхөд ургамлын бие ижилгүй ажилгажээ. Ургамлын иш буюу илчүүний /илчүү-царс, Quercus suber-ээс авсан нимгэн зүсээсийг микроскопоор харж судалснаар ургамлын биө нь хязгааргүй олон тооны өчүүхэн цэврүүнүүдээс тогтсоныг Роберт Гук нээж зөгийн үүрний тортой төстэй байсан тул эс гэж нэрлэжээ. Эс бол амьд бүхний амьдрах чадвартай өчүүхэн нэгж, бие махбодын бүх бололцоог хадгалсан “эгэл бие махбод” болно.

А. Ярианы найруулга  
Б. Сонины найруулга  
Д. Шинжлэх ухааны найруулга  
Е. Уран зохиолын найруулга  
С. Албан бичгийн найруулга

30. Өгөгдсөн эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.

“Тавхай нöён чилжээ  
Таван хиа морджээ  
Гүр багшийг залжээ  
Гүрвэлийн чинээ гайг гаргажээ” (шүдэнд орсон мах авах)

А. Тоочимж  
Б. Тайлбарламж  
Д. Хүүрнэмж  
Е. Харьцууламж  
С. Эргэцүүлэлмж

31. Холбоо үгсийг утга үнэлгэжийн талаас ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.

Монголын үзэсгэлэнт саран гоо намайг төрүүлсэн эжий, төрх ялдам ээж, наран гэрлийн элчтэй саран гоо эжий минь, монголжингоо эжий

А. Бүүвэйн дуу аялсан эжий  
Б. Жилээс жил жижгэрсэн ... ээжий минь  
С. Суутай мэргэдээс илүүтэй сургаал хайрласан эжий минь  
Д. Эгэмнээс минь татаж эрийн зэрэгт оруулсан ээж минь  
Е. Бүйлс цэцэглүүлэл сайхан эжий

32. “Хүүгээ шагнаачихыг бодоорой” гэсэн өгүүлбэрт орсон “шагнаачихыг” гэсэн үгийг зөв задалсан тохиолдлыг ол.

А. Шагна + чих + х + ыг  
Б. Шагна + чих + ыг  
Д. Шан + на + чих + х + ыг  
Е. Шаг + на + чих + ыг  
С. Шан + на + чих + ыг

33. Дараах жагсаалтаас бүгд хэлзүйн шинжээрээ тохирч байгаа хэсгийг ол.

А. Тул, учир, хүртэл, төлөө, сацуу  
Б. Зарим, бүгд, цөм, би, аль, ийм  
С. Дээр, хааяа, гэнэт, голдуу, гэтэл  
Е. Улбар, төвгөр, халуун, зээрд, хэцүү  
Д. Нэн, бүү, маш, тун, биз, лав

34. Дараах үгсийн утга, дарааллыг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.

Ум хумгүй, магнай тэнийх, ухаан жолоогүй, хөл нь газар хүрэхгүй, хуйхуйд хөөгдсөн юм шиг  
А. Үргэсэн янзага шиг  
Б. Хөх инээд хүрэх  
Д. Од нь гялалзах  
Е. Доль цохисон  
С. Нар нь гарах

35. “Шинэ хүргэн ..... цадна” гэсэн хэллэгийн цэгийн оронд тохирох үгийг ол?

А. Хүзүүний маханд  
Б. Магтаалын үгэнд  
Д. Ажлын ихэд  
Е. Хадмын угэнд  
С. Царцааны гуянд

36. Дараах нийлмэл угийн бүтцийг ажиглаад бусдаасаа ялгаатай угийг ол.

A. Хонин гүрвэл      B. Нохойн хошуу      C. Морин хийл  
D. Усан үзэм      E. Мөсөн чихэр

37. Дараах жагсаалтад үл тохирох угийг ол.

A. Хар элгийн      B. Элэг хөших      C. Элэг идэх  
D. Элэг барих      E. Элэг нэгтэй

38. Аль хэсэгт нь үеэр зөв тасалсан байна вэ?

A. Бу - халд - чи - хыг      B. Бух-алд - чих - ыг      C. Бух - алд - чи - хыг  
D. Бу - ха лд - чих - ыг      E. Бухал - д - чих - ыг

39. “Найрагч” гэдэг угийн “ч” авиад үл тохирох шинжийг ол.

A. Зөөлөн      B. Хамжих      C. Дуугүй/чанга  
D. Гийгүүлэгч      E. Хэлний урдуур

40. Дараах дөрвөн хэсгийг зөв байрлуулбал О.Дашбалбарын нэгэн шүлэг болно.

1. Тэнгэр баганадсан уулсыг чинь харнам  
2. Тэргүүн дээр минь алгуурхан нисэлдэж бууна  
3. Тэндээс будрах цагаан цэцэгс  
4. Тэргэл саран оргилд нь даарч хонодог

A. 1, 2, 3, 4      B. 3, 1, 4, 2      C. 4, 3, 2, 1      D. 2, 1, 3, 4      E. 4, 1, 3, 2

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

Хүхдүүд ээ, 2-р хэсгийн даалгавар сонгох тест биш бөгөөд та нар оөрсдөө бодож хариуг бөглөх юм шүү. Дараах хэлцүүдийг угга тохируулан 2.1 хэсэгт бөглөнө уу? Зөв хариулт бүрд нэг оноо огно. (Нийт оноо 8)

- |                              |   |
|------------------------------|---|
| 1. Чөтгөрийн бага адтай      | А. Цаасан малгай өмсгөх                       |
| 2. Сахил хүртээд шал дордов  | Б. Дотор газраас өр нэхэх                     |
| 3. Чоно өтлөвч ишгэндээ      | С. Залхуу хүн завагтаа хүрч чаддаггүй         |
| 4. Үнэг түйцэх               | Д. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох       |
| 5. Нүцгэн хөлт сээр нуруутан | Е. Бурхангүй газар бумба галзуурах            |
| 6. Давирхай халаах           | F. Үхсэн буурын толгойноос амьд ат айх        |
| 7. Чонын эзгүйд чандага ноён | G. Усан нүдэт цусан зүрхт                     |
| 8. Дөтийг харж дөрөв хонох   | H. Туруулж ургасан чихнээс сүүлд ургасан эвэр |

# ХУВИЛБАР Д НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

## Үншиж ойлгоод задлал хийх эх

Миний шүлгүүд эгшиг үсэг  
Би өөрөө балархай эгшиг  
Эцэг минь том үсэг  
Эжий минь  
Эрдмийн заяа гийгүүлсэн  
Эгшиглэнт а үсэг  
Амьдрал минь сонсголонт урт эгшиг  
Амьдрахын тулд хийсэн бүхэн маань  
Үйл үг  
Магтаал хувцас хоёр бол тодотгол  
Алдаа эндүүрэл хоёр минь гээгдэх эгшиг  
Ирээдүй ирээгүй учралууд асуултын тэм  
Эргэн дурсагдах гэнэн залуу нас минь  
Анхаарлын тэмдэг  
Үглэн дуулах минь  
Давхарласан гурван гийгүүлэгч  
Үхэх минь  
Утга төгсгөдөг цэг  
Миний эх орон  
Миний хэлний зүй

(Б.Лхагвасүрэн)

## **Боловсролын Үнэлгээний Төв**

---

1. “Амьдрал” гэдэг үгэнд хэдэн авиа хэдэн үсэг байна вэ?  
A. 7 авиа 6 үсэг      B. 6 авиа 6 үсэг      C. 7 авиа 7 үсэг  
D. 5 авиа 7 үсэг      E. 6 авиа 7 үсэг
2. “Би өөрөө балархай эгшиг” гэдгийн эсрэг утгатай илэрхийллийг ол.  
A. Их мөрөн дөлгөөн      B. Арван хуруу тэгш  
C. Биеэ ихэд, бэтгээ цатгаланд      D. Хал балгүй, мөрөөрөө нэгэн  
E. Хал үзэж хашир суусан
3. “Амьдрахын тулд хийсэн бүхэн маань” гэсэн хэсгийн “-тулд” хэмээх үгийг аль үгээр соливол утга ойролцоо вэ?  
A. Сацуу      B. Зэрэгцээгээр      C. Ялдамд      D. Болон      E. Төлөө
4. “Миний шүлгүүд эгшиг үсэг  
Би өөрөө балархай эгшиг  
Эцэг минь том үсэг  
Эжий минь  
Эрдмийн заяа гийгүүлсэн  
Эгшиглэnt “a” үсэг  
Амьдрал минь сонсголонт урт эгшиг  
Амьдрахын тулд хийсэн бүхэн маань  
Үйл үг” гэсэн хэсэгт төлөөний үг хэд орсон байна вэ?  
A. 1      B. 2      C. 3      D. 4      E. 8
5. 4-р сорилын бичил эхэд “бүтэц өгүүлбэрийн бүтцэд орсон гишүүд ба өгүүлбэрүүдийг зэрэгцүүлж, угсруулж холбох үүрэгтэй туслах үг” хэд байна вэ?  
A. Байхгүй      B. 2      C. 4      D. 5      E. 1
6. 4-р сорилын бичил эхэд нэрлэхийн тийн ялгалын тэг нөхцөлтэй үг хэд байна вэ?  
A. 10      B. 7      C. 5      D. 8      E. 6
7. 4-р сорилын эхийн хэсэгт ямар үгсийн аймгийн үг ороогүй байна вэ?  
A. Жинхэнэ нэр      B. Тэмдэг нэр      C. Үйл үг  
D. чимэх үг      E. Холбох үг
8. 4-р сорилд байгаа хэсгийн “урт эгшиг” гэдэг үг өгүүлбэрийн ямар гишүүн болох вэ?  
A. Шууд бус тусагдахуун      B. Шууд тусагдахуун      C. Өгүүлэгдэхүүн  
D. Байц гишүүн      E. Өгүүлэхүүн
9. 4-р сорилын эхийн хэсэгт үйлийн найрах холбоо үг хэд байна вэ?  
A. 2      B. 3      C. 1      D. 4      E. байхгүй
10. 4-р сорилын бичил эхийн хэсэг ямар өгүүлбэр болох вэ?  
A. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр      B. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр  
C. Нэрлэсэн өгүүлбэр      D. Угсарсан нийлмэл өгүүлбэр  
E. Холимог нийлмэл өгүүлбэр
11. Дээрх шүлгийн “амьдрахын тулд” гэдэг холбоо үгийг зөв тодорхойл.  
A. Чөлөөт холбоо үг      B. Бүхэлзүйжсэн холбоо үг  
C. Утгазүйжсэн холбоо үг      D. Хэлзүйжсэн холбоо үг  
E. Үгийнсанжсан холбоо үг
12. Эхэд байгаа “... эгшиг, ... гийгүүлэгч, ... тодотгол, ... үйл үг, ... асуултын тэмдэг ...” зэрэг үг нь хоорондоо утгын ямар хамаарлтай вэ?  
A. Зүйлчилсэн утгатай      B. Эсрэг утгатай      C. Төсөө утгатай  
D. Ойролцоо утгатай      E. Аль нь ч биш
13. Эхийн сэдвийг ол.  
A. Эх хэл      B. Эх орон      C. Миний амьдрал  
D. Орчлонгийн жам ёс, хүсэл хяслын тухай      E. Хэлзүйн тухай
14. Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?  
A. Нийт 13 цогцолбор      B. Миний амьдрал....., миний эх орон ... гэсэн 2 цогцолбор  
C. Бүхэлдээ нэг л цогцолбор      D. Би ..., миний юм бүхэн..., эх орон минь гэсэн 3 цогцолбор  
E. Би...., эцэг эх минь...., амь амьдрал минь..., эхорон минь... гэсэн 4 цогцолбор
15. Эхийн гол санааг хэлнэ үү.  
A. Би шүлэгч      B. Миний амьдрал төрөлх хэл лугаа адил  
C. Эх орон минь      D. Эх хэлээ хайрлан хамгаалъя  
E. Хүн төрөлхтөн хэлнээсээ ангид байж үл чадна
16. “Миний шүлгүүд эгшиг үсэг  
Би өөрөө балархай эгшиг

- Эцэг минь том үсэг  
 Эжий минь  
 Эрдмийн заяа гийгүүлсэн  
 Эгшиглэнт “а” үсэг  
 Амьдрал минь сонсголонт урт эгшиг  
 Амьдрахын тулд хийсэн бүхэн маань  
 Үйл үг” гэсэн хэсгийн найруулах ур маягийг зөв сонго.
- |             |              |            |
|-------------|--------------|------------|
| A. Зүйрлэл  | B. Тойруулал | C. Егөөдөл |
| D. Адилтгал | E. Төлөөлөл  |            |
17. Холбоо үгсийг утга үнэлэмжийн талаас ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг тавь.  
 Аргаар эвийлж ухаанаар аргадсан ижий, амьдрал гэдгийг таниулсан ижий, ухаанаа асгаж ургуулсан ижий, ухааруулж өсгөсөн ижий
- |  |                         |
|--|-------------------------|
| A. Бүйлс цэцэглүүлэм сайхан ижий                   | B. Саран гоо ижий       |
| C. Жилээс жилд жижгэрсэн ижий                      | D. Цайлган сэтгэлт ижий |
| E. Суутай мэргэдээс илүүтэй сургаал хайрласан ижий |                         |
18. “Нөхөрлөлөө бататгая” гэсэн өгүүлбэрт байгаа “нөхөрлөлөө” гэсэн үгийг зөв задалсан тохиолдлыг ол.
- |                                   |                                 |
|-----------------------------------|---------------------------------|
| A. Нөхөр + л + лөө                | B. Нөхөрлө + лөө                |
| C. Нөх + р + л + л + өө           | D. Нөхөр + л + л + 0 (ийг) + өө |
| E. Нөх + р + л + л + 0 (ийг) + өө |                                 |
19. Дараах үгсийн бүтэц дарааллыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг ол.  
 амт, амсах, амгайвч, амтай, амлах, ...
- |         |          |          |        |                 |
|---------|----------|----------|--------|-----------------|
| A. Амар | B. Амдах | C. Амжих | D. Амь | E. Амуу /тариа/ |
|---------|----------|----------|--------|-----------------|
20. Дараах жагсаалтаас хэлзүйн шинжээрээ үл тохирч байгаа хэсгийг ол.
- |                                     |                                    |
|-------------------------------------|------------------------------------|
| A. Зарим, бүгд, би, аль, хамаг      | B. Ба, бөгөөд, буюу, агаад, болоод |
| C. Дээр, наана, цаана, дэргэд, өмнө | D. Шар, цэхэр, бор, зээрд, дугуй   |
| E. Нэн, бүү, маш, тун, тулд         |                                    |
21. Дараах хэлцийн утгын дарааллын зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг ол.  
 Даахгүй нохой булуу хураах, түрүүний бөөс толгойд, санаа байвч сачий хүрэхгүй, гар бариад бугуй барих, санаа нь дэлхий сачий нь мэлхий, ...
- |   |  |
|---|--|
| A. Суусан газраасаа широо атгах             |  |
| B. Зажлахгүй залгих                         |  |
| C. Түрүү ургасан чихнээс сүүлд ургасан эвэр |  |
| D. Нэг гараараа нөгөө гарaa барих           |  |
| E. Даварсаар даварсаар Дагвуун орон дээр    |  |
22. “Үнэг яараагүй байхад ..... яarah” гэсэн хэллэгийн цэгийн оронд тохирох үгийг ол.
- |         |            |           |          |        |
|---------|------------|-----------|----------|--------|
| A. Чоно | B. Чандага | C. Толгод | D. Анчин | E. Хад |
|---------|------------|-----------|----------|--------|
23. “...Өтөн чинээ хуруутай  
 Өндсөн чинээ хувцастай ... хүү минь” гэсэн шүлгийн үгэнд найруулгын ямар алдаа байна вэ?
- |                      |   |                   |
|----------------------|---|-------------------|
| A. Үг илүүдсэн алдаа | B. Үг давтсан алдаа                       | C. Баримтын алдаа |
| D. Хэлзүйн алдаа     | E. Яруу хэрэглүүр оновчгүй сонгосон алдаа |                   |
24. Дараах жагсаалтыг уншаад буруу зүйлчилсэн хэсгийг ол.
- |  |  |
|--|--|
| A. Нэвтэрхий толь, гарын авлага, өгүүлэл, зөвлөмж, ганц сэдэвт зохиол, туульс  |  |
| B. Заавар, тайлан, мэдэгдэл, төсөл, санал танилцуулга, албан даалгавар   |  |
| C. Төрийн сүлд соёмбо, байгууллагын нэр, байгууллагын хаяг, илгээж байгаа бичгийн нэр, огноо гарын үсэг, тамга, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэл |  |
| D. Найруулал, шог найруулал, сурвалжилга, тэмдэглэл, гашуудлын мэдээ, хөрөг нийтлэл  |  |
| E. Роман, тууж, шүлэг, найраглал, дууль, өгүүллэг  |  |
25. Дараах загвар ямар найруулгынх вэ?
- Намтрын хэсэг (Хэний хэн. Хэдэн онд хаана төрсөн. Ам бүл. Төгссөн сургууль курс)
  - Эзэмшсэн мэргэжил. (Гишүүнчлэл)
  - Ажлын байдал (Хэдээс хэдэн онд хаана ямар ажил хийж байсан. Одоогийн ажил юу болох. Ажлын буюу сурлагын амжилт юу болох. Гаргасан санаачилга, бүтээл туурвил)
  - Гавьяя шагнал (...)
  - Үнэлэлт
  - Тодорхойлолт
- |                                |                                 |
|--------------------------------|---------------------------------|
| A. Ярианы хэлний найруулга     | B. Сонин нийтлэлийн найруулга   |
| C. Албан бичгийн хэл найруулга | D. Эрдэм шинжилгээний найруулга |
| E. Уран зохиолын найруулга     |                                 |

## Боловсролын Үнэлгээний Төв

26. Доор өгөгдсөн эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.

“Сайн морины гадар бэлгэ нь:  
Тэргүүн нь тэмээний тэргүүн мэт  
Хамар нь бүрээний амсар мэт  
Уруул нь хандгайн уруул мэт  
Нүд нь мэлхийн нүд мэт  
Дух нь тэмээний дух мэт  
Хүзүү нь арслангийн хүзүү мэт  
Мөр нь бүргэдийн мөр мэт ...”



27. Доорх жагсаалтаас зөвхөн зохиолч Ч.Лодойдамбын бичсэн зохиолуудыг олно уу.

- A. Тунгалаг Тамир, Хугараагүй ноён нуруу, Алтайд, Шаргачин
  - B. Тунгалаг тамир, Хугараагүй ноён нуруу, Чөтгөр, Алтайд
  - C. Тунгалаг тамир, Алтайд, Тээрэмчин, Чулуун
  - D. Тээрэмчин, Далан худалч, Малын хөлийн тоос, Яг арван найм
  - E. Тунгалаг Тамир, Хугараагүй ноён нуруу, Солонго, Хулан бид хоёр

28. “Монголын нүүц товчоо” зохиолд тайчуудтай тулалдахын өмнө

“Довтлон орох чадалгүй боловч  
Тогтсоныг бататгах чадалтай би  
Эрчлэн дайрах чадалгүй боловч  
Эвдэрснийг сэлбэх чадалтай би ...  
Уулгалан орох цаг болоход  
Ухрах зугтах магадгүйг  
Урдаас хаандаа хэлье ...” гэж хэнээс хандаж хэнд хэлдэг вэ?

- A. Мухулагайгаас хандаж Чингис хаанд  
C. Шихихутагаас хандаж Тэмүүжиннд  
E. Зэлмээс хандаж Тэмүүжиннд

B. Боорчоос хандаж Чингис хаанд  
D. Чуу мэргэнээс хандаж Чингис хаанд

29. Дараах шүлгийн мөрийг уншаад өгөгдсөн хувилбаруудаас зөв сонгож гүйцээхдээ зохиолчийнхoo нэртэй тохирч байхаар гүйцэтгээрэй.

Үзээд өнгөрөх амьдралыг мөнхийн юм шиг бодож  
Үдлээд буцах хорвоог үүрдийн юм шиг сэтгэж  
Залуу, идэр насaa хөгшрөхгүй юм шиг санаж

- A. Замба тивийн наран доор гундаж яваа дүү минь, О.Дашбалбар
  - B. Замбуулин хорвоогийн наран доор жаргаж яваа дүү минь, Б.Лхагвасүрэн
  - C. Замбуулин хорвоогийн наран доор жаргаж яваа дүү минь, О.Дашбалбар
  - D. Замба тивийн элгэн дээр туйлж яваа дүү минь, О.Дашбалбар
  - E. Замба тивийн элгэн дээр туйлж яваа дуу минь, Б.Лхагвасүрэн

30. Дараах хувилбаруудыг ажиглаад, төрөл зүйлээр бүрэн ижилссэн хэсгийг одно уу.

- A. Үлгэр, өгүүллэг, туульс, түүж  
C. Өгүүллэг, түүж, роман, бээрэг түүж  
E. Өгүүллэг, түүж, роман, найрагал

B. Оньсого, цэцэн уг, жүжиг, ертөнцийн гурав  
D. Оньсого, цэцэн уг, ерөөл, шүлэг

31. Нэрээс үйл үг бүтээх “-д” дагавар залгахад зөв бичгийн дүрмээр аль нь ялгаатай бичигдэх вэ? /кирилл/  
А. Сээрээ -      Б. Хүзүү -      С. Шүүр -      Д. Хурз -      Е. Халбага -

- " гэсэн уйл үндсэнд дараах нөхцөлүүлийг залгахад зөв бичгийн дурмээр аж

52. Всё тусий түндээлд дараах нождлүүдийн залжадаад зөв ойн нийн дүрмээр аль нь буудаасаа онцлогт бичигдэх вэ? /кирилл/

- Ингийн дурмэрээр бүх уг ш. алдаагүй бишээн хөснийг од.

33. Зөв бичгийн дүрмээр бүх үзүүлэлтүүдийг алдаагүй бичсэн хэсгийг олж, ААМ-ын дадарыг иргэнийн хайнала захвасаар

- А. Амьдралыг, урлагийн, хайчла, загвараар
  - Б. Үндсийг, хураачихаад, нөхцөлийг, бухалдчихаад
  - С. Гаргачих, сонсоцгоо, өгчихөөд, гударчхаад
  - Д. Хаячихсан, ногтол, эрхтэний, харьдгийг
  - Е. Илчихээд, тугаллалаа, ачийг, тусалья

34. Монгол бичгээр бичихэд дөрвөн уеэс бутэх угийг од.

- А. Амьсгал В. Амрадт С. Сурагч Д. Ганзага Е. Хөвгүүн

35. Монгол бичгээр бичихэд аль уйл уг нь хатuu дэвсгэрээр тэгсөх вэ?

- А Зар - В Зөр - С Хөмөр - Д Зандар - Е Найр-

34. Дараах нийлмэл үгсийн бүтцийг ажиглаад бусдаасаа ялгаатай үгийг ол.
- A. Эдийн засагч                    B. Нохойн хошуу                    C. Туулайн бөөр  
 D. Ямаан ууц                      E. Хонин гүрвэл
35. Өгөгдсөн сургаал үгийг зөв сонгож гүйцээ.  
 “Нохойноосоо гинж нь
- .....
- A. Барилдахаасаа таахалзах нь            B. Ноёнаосоо түшмэл нь            C. Хийхээсээ хээхэлзэх нь  
 D. Ноёнаосоо бөх нь                        E. Ноёнаосоо боол нь
36. Аль хэсэгт нь үеэр зөв тасалсан байна вэ?
- A. Ар - чуу - лах - ад                    B. Ар - чуул - ах - ад            C. Ар - чуу - ла - хад  
 D. Арч - уул - ах - ад                    E. Арч - уул - х - д
37. “Болсон” гэдэг үгийн нэгдүгээр үеийн “о” авианд үл тохирох шинжийг ол.
- A. Хэлний дундуурх                        B. Эр чанга                            C. Уруулын  
 D. Дунд                                        E. Өргөлтөт
38. Дараах дервөн хэсгийг зөв байрлуулбал зохиолч Б.Лхагвасүрэнгийн “Шөнө дунд адуу тургилав” шүлгийн хэсэг болно.
1. Гэрт тогтомгүй сэтгэл гэгэлзэв                    2. Шуугиант хотын зуслан сэжүүрт  
 3. Гэгээн зүүд тал руу хулжиж                        4. Шөнө дунд адуу тургилав  

A. 1, 2, 3, 4                                    B. 1, 3, 2, 4                            C. 3, 2, 1, 4  
 D. 2, 3, 4, 1                                    E. 2, 4, 3, 1

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

**Хүүхдүүд ээ, 2-р хэсгийн даалгавар сонгох тест биш бөгөөд та нар өөрсдөө бодож хариуг нь бөглөх юм шүү.  
 Дараах хэлцүүдийг утга тохируулан 2.1 хэсэгт бөглөнө үү. Зөв хариу бүрт 1 оноо өгнө. (Нийт оноо 8)**

- |   |   |
|---|---|
| 1. Гүзээнд наалдсан дэлүү шиг           | a. Нойтон хамуу                             |
| 2. Гүзээ шороодох                       | б. Хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав |
| 3. Могой гурав тасравч гүрвэлийн дайтай | с. Цаасан малгай өмсгөх                     |
| 4. Ташуур алдам                         | d. Үхсэн буурын толгойноос амьд ат айна     |
| 5. Бяруу болоогүй байж бух болох        | e. Аавын цээж                               |
| 6. За гэвэл ёогүй                       | f. Чөтгөр тогтмооргүй                       |
| 7. Давирхай халаах                      | g. Хадан гэртээ очих                        |
| 8. Алаагүй үнэгний арьс                 | h. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий             |

## 2006 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

№	Нэгдүгээр хэсэг			
	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С	Хувилбар D
1	B	B	E	E
2	D	A	D	C
3	B	D	C	E
4	C	E	B	D
5	A	A	B	E
6	D	B	A	E
7	B	C	D	D
8	E	B	B	E
9	A	C	C	A
10	B	A	A	E
11	D	C	A	D
12	B	B	C	A
13	A	E	E	C
14	D	A	C	B
15	E	B	D	B
16	A	D	E	D
17	B	A	C	E
18	C	D	B	D
19	D	D	E	B
20	A	D	B	A
21	E	B	E	E
22	C	D	B	E
23	B	D	E	E
24	B	D	E	A
25	D	B	A	C
26	B	C	E	A
27	C	C	D	A
28	A	B	C	D
29	D	A	D	D
30	E	B	D	C
31	C	E	E	D
32	C	A	D	D
33	C	C	C	E
34	A	D	C	B
35	E	B	C	D
36	B	D	B	A
37	B	E	C	E
38	C	A	A	C
39	E	B	B	C
40	E	B	E	E

Хоёрдугаар хэсэг				
№	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С	Хувилбар D
a	5	8	6	1
b	3	6	4	6
c	6	7	8	7
d	1	5	2	3
e	4	3	7	5
f	2	4	3	4
g	8	2	5	2
h	7	1	1	8